

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ГАДААД АЖИЛТНЫ ТОО, ХУВЬ ХЭМЖЭЭ ТОГТООХГҮЙ БАЙХ, ГАДААД АЖИЛТНЫ АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Уул уурхай, газрын тос олборлох үйл ажиллагаанаас бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбарт 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй бөгөөд энэ хугацаанд ажил олгогчийг гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг тус тус нэмсүгэй.

1/22 дугаар зүйлийн 22.7, 22.8 дахь хэсэг:

“22.7. Уул уурхай, газрын тос олборлох үйл ажиллагаанаас бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбарт гурав хүртэлх жилийн хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байж болно. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх хугацаа, энэхүү хугацаанд гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх эсэхийг Монгол Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

22.8. Монгол Улсад үйлдвэрлэлийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, угсрах, засварлахад ажил олгогчид шаардлагатай түр ажилтанг энэ хуулийн 22.1-д заасан тоо, хувь хэмжээг үл харгалзан гадаад улсаас гурван сар хүртэл хугацаанд гадаад ажилтан авч болно.”

2/29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг:

“29.5. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 29.4-т заасны дагуу ажил олгогчийн ирүүлсэн мэдээллийг гадаадын иргэн, харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад даруй хүргүүлнэ.”

3/30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг:

“30.3. Энэ хуулийн 30.1-д заасан гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох тохиолдол үүссэн, эсхүл гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан бол ажил олгогч нь энэ тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад даруй мэдэгдэх үүрэгтэй.”

4/32 дугаар зүйлийн 32.10 дахь хэсэг:

“32.10. Энэ хуулийн 22.7-д заасны дагуу Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй хугацаанд гадаад ажилтны ажлын

байрны төлбөрөөс ажил олгогчид хөнгөлөлт үзүүлсэн бол тухайн ажлын байранд Засгийн газрын шийдвэрээр давхардуулан нэмэлт хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхгүй.”

2 дугаар зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/25 дугаар зүйлийн 25.1.4 дэх заалт:

“25.1.4.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1.1-д заасан үүргээ биелүүлээгүй нь тогтоогдсон, эсхүл энэ хуулийн 29.4-т заасан тохиолдолд гадаад ажилтныг Монгол Улсын хилээр гаргаж, энэ тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй, эсхүл энэ хуулийн 30.3-т заасан мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;”

2/33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг:

“33.1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний мэдээллийн сан нь монгол ажилтан, гадаад ажилтны цаасан болон цахим мэдээлэл, энэ хуулийн 23.2-т заасан ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны мэдээллээс бүрдэнэ.”

3 дугаар зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн “нэг жил хүртэл” гэснийг “нэг жил хүртэл, эсхүл энэ хуулийн 22.7-д заасны дагуу хуульд заасан хугацаатай” гэж, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “нэг сард ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх” гэснийг “нэг сард ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.13 дугаар зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль зөрчих

1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хууль бус хөдөлмөр эрхлүүлсэн бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлмөр эрхэлсэн хугацааны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлөөгүй бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хуульд заасан бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах үүргээ биелүүлээгүй, эсхүл, гадаад ажилтныг хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтад хамруулаагүй, эсхүл, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан, эсхүл гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, эсхүл гадаад ажилтныг өөр ажил олгогчид шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд ажил олгогч хуульд заасан хугацаанд гадаад ажилтныг Монгол Улсын хилээр гаргаж, энэ тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Ажил олгогч гадаад улсаас ажилтан авах зорилгоор тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжил, ур чадварыг хэт өндөр тавих, ажлын байрны шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс

үндэслэлгүйгээр татгалзсан нь тогтоогдсон бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан иргэний бүртгэл хөтлөөгүй, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд өгөөгүй, худал тайлан өгсөн бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч зуучлуулагчтай зуучлалын гэрээ байгуулаагүй, зуучлуулагчаас хууль бусаар төлбөр хураамж, барьцаа, бэлэн мөнгө авсан бол хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Зөвшөөрөлгүйгээр иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан, хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: “Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн” гэж Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүйгээр гадаад улсын иргэн, эсхүл харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн, эсхүл 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт заасан гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан, эсхүл гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох тохиолдол үүссэн, эсхүл 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасан гадаад ажилтныг өөр ажил олгогчид шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлснийг ойлгоно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг